



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.10.17 № НХТ/2906
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

1.Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журмыг Засгийн газар батална” гэж, мөн зүйлийн 47.14 дэх хэсэгт “Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн, зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана” гэж тус тус заасан.

Үүний дагуу Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 465 дугаар тогтоолоор “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ыг, Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор “Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэр” болон “Зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох Монголбанкны болон зах зээлийн үнийн эх сурвалж нэр”-ийг тус тус батлан мөрдүүлж байна.

Энэ хүрээнд тухайлбал, нүүрсний хувьд БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалж (sxcoal.com), төмрийн хувьд (custeel.net), хайлуур жоншийн хувьд (fastmarkets.com) гэх зэргээр тухайн уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн эх сурвалжийг тогтоож зарласан байдаг.

2.Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 345 дугаар тогтоолоор Уул уурхайн бүтээгдэхүүний бирж (Монголын хөрөнгийн бирж)-ийн арилжааны үнийн мэдээллийг зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ, үнэлгээний үндэслэл болгох зах зээлийн үнийн эх сурвалж байхаар мөн тогтоосон болно.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд ашигт малтмал экспортлогч аж ахуйн нэгж нь тухайн төрлийн экспортын бүтээгдэхүүний дөрөвний нэг, түүнээс дээш хувийг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан тохиолдолд нийт экспортод гаргасан тухайн төрлийн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг “Биржийн болон зах зээлийн

000255014685

үнийн эх сурвалжийн нэр зарлах тухай” Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Уул уурхайн бүтээгдэхүүний бирж (Монголын хөрөнгийн бирж)-ийн арилжааны үнээр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахаар шийдвэрлэсэн.

Хууль тогтоогчоос хуулиар эрх олгосны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасныг үндэслэн “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-д дээрх агуулга бүхий нэмэлт оруулсан Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар тогтоол нь хууль зөрчөөгүй, түүнчлэн Улсын Их Хурлын татварын хувь тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох бүрэн эрхэд халдаагүй болно.

Уг тогтоол батлагдсанаар гадаадын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүнд ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг аж ахуйн нэгжийн гэрээний үнэ бус, борлуулалтын бодит үнэлгээнд үндэслэн тогтоох боломж бүрдэхийн зэрэгцээ биржийн арилжаа идэвхжиж, аж ахуйн нэгжийн борлуулсан бүтээгдэхүүнийг ил тод, нээлттэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид арилжаалах нөхцөл бүрдсэн.

3.Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоол батлагдахаас өмнө буюу 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар нийт 7.5 сая тонн нүүрсийг 2.0 их наяд төгрөгөөр арилжаалж, худалдагч компаниуд арилжааны үеийн өсөлтөөс нийт 97.8 тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг олж байсан бол өмнөх оны мөн үед нийт 16.6 сая тонн нүүрсийг 6.6 их наяд төгрөгөөр арилжаалж, худалдагч компаниуд арилжааны үеийн өсөлтөөс нийт 710.0 тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг олж байжээ.

Харин уг тогтоол батлагдсан өдрөөс хойших 55 хоногийн хугацаанд биржийн арилжаагаар нийт 6.5 сая тонн борлуулсан нь нүүрсний нийт экспортын 21.8 хувьд хүрч нэмэгдсэн байна.

Түүнчлэн, биржийн арилжаа эрчимжсэнээр тухайлбал, коксжих нүүрсний үнэ 2025 оны 07 дугаар сард 88.3 ам.доллар байсан бол мөн оны 09 дүгээр сард 96.04 ам.долларт хүрч, биржийн үнэ болон урт хугацаат гэрээний үнийн зөрүү 56.1 хувьтай болсон.

Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоол батлагдсанаар биржийн нийт арилжаа 25 хувьд буюу 21.3 сая тоннд хүрснээр борлуулалтын орлого 5.6 их наяд, нэмэлт орлого 300.7 тэрбум төгрөгт хүрэх буюу өмнөх оны мөн үеэс 130.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэсэн урьдчилсан тооцоо гарсан.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоол гарснаар татварын бааз суурь өргөжих боломж бүрдэж, төсвийн орлогыг бодитой нэмэгдүүлэх тул энэхүү шийдвэрт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь заалт хамаарахгүй юм.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ